



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 16/08

Арвайхээр сум

“Баянтээг түлш” Орон нутгийн өмчит ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Баянтээг Түлш ХХК”-ийн дүрмийн 6.3.4, 7.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянтээг түлш” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ердийн гишүүд:
- Г.Дэлгэрмандах (аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
 - Б.Сайнбилэг (аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
 - Б.Даваацэрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодис хариуцсан мэргэжилтэн)
 - Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Хөрөнгийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)
 - Л. Дүүмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Уул уурхай, газрын харилцаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)
 - Л. Ганзориг (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
- Хараат бус гишүүд:
- Ц.Лүндээжанцан (Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
 - Оюунбилэг (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораторийн эрхлэгч)
 - Д. Цэцэгмаа (Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, ажлаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 14 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ